

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН  
ЗУРГААДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
/2018.05.26-2018.06.15/

2018 оны 06 дугаар  
сарын 16-ны өдөр

Даланзадгад сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2018 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

1.1. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны хүрээнд:

Тайлант хугацаанд “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу хилийн боомтод виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан нийт БНХАУ-ын 7 иргэнд зохих ангиллын визийг олгож төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- TS /double-re-entry/-1
- B /multiple-entry/-3
- Визийн шилжүүлэг-3

Нийт 7 гадаадын иргэнд виз олгож, визийн хуудасны үнэ болох 50944 /тавин мянга есөн зуун дөчин дөрвөн/ төгрөгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Голомт банкны 1320000114 тоот дансанд, тэмдэгтийн хураамжийн 888000 /найман зуун наян найман мянган/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын 100111600941 тоот дансанд тус тус тушаалган ажилласан болно.

Виз хүчингүй болгосон талаар:

БНХАУ-ын 3 иргэний “В” ангиллын олон удаагийн визийг “Монгол Улсын виз олгох журам”-ын 5.3.3 дахь заалтыг үндэслэн хүчингүй болгосон.

Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын нийт 2782 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

*Орох чиглэлд:1423*

*Гарах чиглэлд:1359*

**Гашуунсухайт боомт**

- Орох чиглэл -658
- Гарах чиглэл-588

**Шивээхүрэн боомт**

- Орох чиглэл – 765
- Гарах чиглэл-771

1.2. Түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт:

Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн болон захиргааны арга хэмжээ авагдсан, албадан гаргагдсан нийт 90 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 9 иргэний хасалт хийж ажилласан байна.

1.3. ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 47 иргэнийг бүртгэж, 46 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар: Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн болон албадан гаргагдсан БНХАУ-ын нийт 67 гадаадын иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

1.4. Хилийн чанад болон Гадаадын иргэн, харьяатын газарт алдаатай олгогдсон, зөвшөөрөлгүй олгогдсон визийг засварласан болон хүчингүй болгосон талаар:

Тайлант хугацаанд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Консулын газраас тус улсын 5 иргэнд олгосон В ангиллын визийн хүчинтэй хугацааг алдаатай олгосон байсныг засварлаж, визийн тэмдгээр баталгаажуулан, хил нэвтрүүлсэн.

1.5. Гадаадын иргэдийн хяналт шалгалтын хүрээнд:

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 1 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтад 18 аж ахуйн нэгж, байгууллагын 1 /БНХАУ/ улсын нийт 97 гадаадын иргэн хамрагдсан байна.

Тус бүсийн газрын даргын ӨМ-2018/06 тоот удирдамжаар Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэдийн баримт бичигт хяналт шалгалт хийж, нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 6 иргэнийг албадан гаргаж ажилласан.

1.6. Албадан гаргасан талаар:

ГИЭЗБТХ-ийн 37.1.7 дахь заалтыг үндэслэн байгууллагын даргын 2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/197 дугаар тушаалаар БНХАУ-ын 6 иргэнийг албадан гаргаж ажилласан.

1.7. Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:

Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор ГИЭЗБТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.6 дэх заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын виз олгох журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 30 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцааж ажилласан.

1.8. Торгуулийн арга хэмжээ авагдсан талаар:

Зөрчлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн БНХАУ-ын 7 иргэнд нийт 610.000 /зургаан зуун арван мянган/ төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч улсын төсөвт төвлөрүүлэн, зөрчлийг арилгаж ажилласан байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

## 2.1. Захиргааны чиглэлээр хийсэн ажил:

Өмнөговь аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуулийн сургалтыг 2018 оны 06 дугаар 08-ны өдөр зохион байгуулсан бөгөөд сургалтад Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нар хамрагдаж мэдлэгээ бататган ажиллалаа.

Өмнөговь аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газартай хамтран “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалтыг 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдөр газрын төвийн 10 албан хаагчдад зохион байгууллаа.

Тус газрын шинээр баригдахаар төлөвлөж буй албаны орон сууцны шугам сүлжээ, мэдээлэл холбоо, ус хангамж, цахилгааны техникийн нөхцөл гаргуулах хүсэлт, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХК, Гүний Ус ХК, Даланзадгадын ДЦС ТӨХК-иудад энэ оны 05 дугаар сарын 24-ний өдрийн албан бичгээр уламжлан хүргүүлснээр техникийн нөхцөлийг тус тус гаргуулаад байна.

## 2.2. Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/- 0
  - Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо- 0
  - Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо /Ерөнхий газарт/-0
  - Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
  - Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-0/
  - Ерөнхий газраас ирсэн бичиг-5
  - Ерөнхий газарт явуулсан бичиг /албан тоот-0, илтгэх хуудас-5/
  - Бусад байгууллагад хүргүүлсэн бичиг /албан тоот-4/
  - Бусад байгууллагаас ирсэн бичиг-2
  - Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

## 2.3. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тус Газрын 05 дугаар сарын шилэн дансны мэдээллийг шивж, мэдээг Санхүүгийн хэлтэс, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Газрын 2018 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Энэ оны 06 дугаар сард 18 албан хаагчийн урьдчилгаа цалинд 5.000.000 төгрөгийг олгож шатах, тослох материалын зардалд 1.500.000 төгрөгийн гүйлгээ хийж ажилласан.

Төрийн аудитын газраас 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн шалгалтын дагуу ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг гарган 2018 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 31 дугаар илтгэх хуудсаар Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст, 06 дугаар сарын 07-ны өдрийн газрын даргын 14/61 дугаар албан бичгээр Өмнөговь аймгийн Төрийн аудитын газар, ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст тус тус хүргүүлэн ажиллалаа.

## 2.4. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган, бүсийн хэмжээнд гарсан эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын цахим хуудсанд тус газрын 2018 оны 06 дугаар сарын төлөвлөгөө, 05 дугаар сарын

төлөвлөгөөний биелэлт, тайлан, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР